

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2025/137/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Өлгий хот	Утас: 70422954 Цахим хаяг: J_aigul@yahoo.com
2025 он	Аудитын менежер: Х.Женисбек
	Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
	Аудитор: С.Нурлан
	Утас: 99103281 Цахим хаяг: nurlans@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал.....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
4.5.1 Завсрын аудитын талаар.....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Төлбөрийн акт.....	17
Төлбөрийн акт тогтоогдоогүй.....	17
5.2 Албан шаардлага.....	17
5.3 Зөвлөмж	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

ТОЛБО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Т.РАШАТ ТАНАА

2025.02.28 № 329
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй

Аудитын гол асуудал

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>67,543,628.00</u>	<u>49,621,628.00</u>
33	АВЛАГА	8,473,000.00	8,193,000.00
335	Бусад авлага	8,473,000.00	8,193,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	8,473,000.00	8,193,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	59,070,628.00	41,428,628.00
354	Хангамжийн материал	59,070,628.00	41,428,628.00
35410	Бичиг хэргийн материал	275,000.00	805,000.00
35420	Аж ахуйн материал	8,895,628.00	17,050,628.00
35470	Бусад хангамжийн материал	49,900,000.00	23,573,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,403,130,774.60</u>	<u>4,287,089,620.76</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,403,130,774.60	4,287,089,620.76
392	Биет хөрөнгө	4,386,468,774.60	4,259,476,446.20
39201	Барилга, байгууламж, орон сууц	968,071,931.00	968,071,931.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(397,387,053.54)	(446,046,579.38)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	131,639,994.00	166,812,494.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(123,903,745.60)	(128,051,202.41)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	557,412,734.00	607,336,834.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(312,635,118.50)	(360,078,227.44)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,372,872.00	24,605,872.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13,922,302.92)	(16,032,613.67)
39209	Зам, гүүрийн байгууламж	39,500,000.00	39,500,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(4,279,166.71)	(8,229,166.75)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	5,234,600.00	5,234,600.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,735,466,488.00	3,797,818,888.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(217,102,457.13)	(391,466,383.15)
393	Биет бус хөрөнгө	16,662,000.00	27,613,174.56
39301	Програм хангамж	1,486,400.00	3,679,639.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,486,400.00)	(1,499,233.33)
39303	Бусад биет бус хөрөнгө	16,662,000.00	25,457,200.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	(24,431.11)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,470,674,402.60</u>	<u>4,336,711,248.76</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>3,809,715.00</u>	=
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,809,715.00	-
413	Өглөг	3,809,715.00	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	3,809,715.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,466,864,687.60</u>	<u>4,336,711,248.76</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	4,466,864,687.60	4,336,711,248.76
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	490,884,758.00	490,884,758.00

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51101	Өмч: - төрийн	490,884,758.00	490,884,758.00
512	Хуримтлагдсан үр дүн	3,545,894,140.19	3,415,740,701.35
51210	Өмнөх үеийн үр дүн	3,545,894,140.19	3,545,894,140.19
51220	Тайлант үеийн үр дүн	-	(130,153,438.84)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	430,085,789.41	430,085,789.41
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4,470,674,402.60</u>	<u>4,336,711,248.76</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,921,290,597.34	1,131,075,187.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,337,716,808.00	182,078,439.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,337,716,808.00	182,078,439.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	3,317,716,808.00	164,670,439.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	20,000,000.00	17,408,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	583,573,789.34	948,996,748.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	33,538,091.00	36,099,448.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,837,591.00	7,308,648.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	31,700,500.00	28,790,800.00
131106	Төсвийн урамшуулал	-	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	550,035,698.34	912,897,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	550,035,698.34	912,897,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	733,556,051.91	1,261,228,625.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	733,556,051.91	1,261,228,625.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	725,175,797.91	1,192,268,780.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	391,385,422.34	700,111,777.50
210101	Үндсэн цалин	274,318,745.45	401,635,930.00
210102	Нэмэгдэл	110,436,636.89	289,241,341.50
210104	Урамшуулал	6,630,040.00	9,234,506.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,448,999.00	90,539,698.00
210201	Тэтгэврийн даатгал	33,625,538.00	60,620,198.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,955,938.00	7,479,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,164,372.00	3,739,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	791,066.00	3,739,900.00

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210205	Эрүүл мэндийн даатгал	7,912,085.00	14,959,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,257,401.00	3,780,985.00
210301	Гэрэл, цахилгаан	1,099,501.00	3,280,985.00
210302	Түлш, халаалт	24,157,900.00	500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,173,504.00	33,755,473.00
210401	Бичиг хэрэг	1,820,000.00	3,009,000.00
210402	Тээвэр, шатахуун	17,330,604.00	25,455,773.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,695,900.00	4,353,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	469,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	327,000.00	468,000.00
2105	Нормативт зардал	430,000.00	700,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	430,000.00	700,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,814,000.00	2,402,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	714,000.00	843,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	59,500.00
210604	Урсгал засвар	1,100,000.00	1,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,812,000.00	6,351,000.00
210702	Дотоод албан томилолт	2,812,000.00	6,351,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,237,124.00	6,416,104.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	31,417,100.00	5,080,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	145,300.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	25,560.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	532,100.00	981,000.00
210807	Газрын төлбөр	97,624.00	284,744.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	45,000.00	44,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	198,617,347.57	348,210,842.84
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	48,834,518.67	66,592,250.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	714,000.00	907,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	149,068,828.90	280,711,592.84
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,380,254.00	68,959,845.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	37,902,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	37,902,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	8,380,254.00	31,057,845.50
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,380,254.00	31,057,845.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>3,187,734,545.43</u>	<u>(130,153,438.84)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>3,187,734,545.43</u>	<u>(130,153,438.84)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>583,573,789.34</u>	<u>948,996,748.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	583,573,789.34	948,996,748.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	33,538,091.00	36,099,448.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,837,591.00	7,308,648.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	31,700,500.00	28,790,800.00
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	550,035,698.34	912,897,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	550,035,698.34	912,897,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>567,267,989.34</u>	<u>948,996,748.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	567,267,989.34	948,996,748.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	558,887,735.34	880,036,902.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	387,575,707.34	700,963,292.50
210101	Үндсэн цалин	270,016,602.45	402,487,445.00
210102	Нэмэгдэл	110,929,064.89	289,241,341.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	6,630,040.00	9,234,506.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,448,999.00	93,497,898.00
210201	Тэтгэврийн даатгал	33,625,538.00	63,578,398.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,955,938.00	7,479,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,164,372.00	3,739,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	791,066.00	3,739,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,912,085.00	14,959,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,257,401.00	3,780,985.00
210301	Гэрэл, цахилгаан	1,099,501.00	3,280,985.00
210302	Түлш, халаалт	24,157,900.00	500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,248,504.00	33,785,473.00
210401	Бичиг хэрэг	1,820,000.00	3,039,000.00
210402	Тээвэр, шатахуун	17,330,604.00	25,455,773.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,770,900.00	4,353,500.00
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		469,200.00

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	327,000.00	468,000.00
2105	Нормативт зардал	430,000.00	700,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	430,000.00	700,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,814,000.00	2,802,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	714,000.00	1,243,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		59,500.00
210604	Урсгал засвар	1,100,000.00	1,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,812,000.00	6,351,000.00
210702	Дотоод албан томилолт	2,812,000.00	6,351,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36,237,124.00	6,516,104.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	35,417,100.00	5,180,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	145,300.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар		25,560.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	532,100.00	981,000.00
210807	Газрын төлбөр	97,624.00	284,744.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	45,000.00	44,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,064,000.00	31,639,250.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,350,000.00	30,577,250.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	714,000.00	1,062,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,380,254.00	68,959,845.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	37,902,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		37,902,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,380,254.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,380,254.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	31,057,845.50
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	31,057,845.50
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	16,305,900.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	16,305,900.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	16,305,900.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	16,305,900.00	
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(16,305,900.00)</u>	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(100.00)	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	100.00	

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
-----------	--	--	--

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	490,884,758.00	430,085,789.41	3,545,894,140.19	4,466,864,687.60
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	490,884,758.00	430,085,789.41	3,545,894,140.19	4,466,864,687.60
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	490,884,758.00	430,085,789.41	3,545,894,140.19	4,466,864,687.60
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	490,884,758.00	430,085,789.41	3,545,894,140.19	4,466,864,687.60
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	490,884,758.00	430,085,789.41	3,545,894,140.19	4,466,864,687.60
D08	Тайлант үеийн үр дүн			(130,153,438.84)	(130,153,438.84)
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	490,884,758.00	430,085,789.41	3,415,740,701.35	4,336,711,248.76

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	985,440,700.00	895,636,579.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	985,440,700.00	895,636,579.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	946,487,700.00	857,734,579.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	747,987,600.00	700,963,292.50
210101	Үндсэн цалин	407,248,000.00	402,487,445.00
210102	Нэмэгдэл	321,303,600.00	289,241,341.50
210104	Урамшуулал	19,436,000.00	9,234,506.00

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	93,498,500.00	93,497,898.00
210201	Тэтгэврийн даатгал	63,579,000.00	63,578,398.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,479,900.00	7,479,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,739,900.00	3,739,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,739,900.00	3,739,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,959,800.00	14,959,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,971,400.00	3,780,985.00
210301	Гэрэл, цахилгаан	1,500,000.00	3,280,985.00
210302	Түлш, халаалт	33,971,400.00	500,000.00
210303	Цэвэр, бохир ус	500,000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	32,813,200.00	32,580,400.00
210401	Бичиг хэрэг	3,042,000.00	3,039,000.00
210402	Тээвэр, шатахуун	24,247,700.00	24,250,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,353,500.00	4,353,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	700,000.00	469,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	470,000.00	468,000.00
2105	Нормативт зардал	700,000.00	700,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	700,000.00	700,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,886,600.00	2,802,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,243,400.00	1,243,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	143,200.00	59,500.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	6,100,000.00	5,331,000.00
210702	Дотоод албан томилолт	6,100,000.00	5,331,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,968,400.00	6,516,104.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,254,400.00	5,180,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	513,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	184,800.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	392,000.00	25,560.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	120,400.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	981,000.00	981,000.00
210807	Газрын төлбөр	478,500.00	284,744.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	44,300.00	44,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,562,000.00	11,562,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,500,000.00	10,500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,062,000.00	1,062,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,953,000.00	37,902,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,953,000.00	37,902,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	37,902,000.00	37,902,000.00

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,051,000.00	
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	985,440,700.00	895,636,579.50
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	985,440,700.00	895,636,579.50
132001	Орон нутгийн төсвөөс	985,440,700.00	895,636,579.50
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25.00	25.00
620001	Удирдах ажилтан	9.00	9.00
620002	Гүйцэтгэх ажилтан	8.00	8.00
620003	Үйлчлэх ажилтан	3.00	3.00
620004	Гэрээт ажилтан	5.00	5.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25.00	25.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9.0	9.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	3.0	3.0
650010	Гэрээт ажилтан	5.0	5.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	8.0	8.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,465,998.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,465,998.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,465,998.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,465,998.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,465,998.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,797,125.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	13,797,125.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	24,263,123.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	24,263,123.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	20,263,123.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Толбо сумын Засаг даргын тамгын газар нь харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөгөө зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, Засаг даргын бүрэн эрхийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, ИТХ, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах, хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах чиг үүрэг бүхий байгууллага юм.

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тайлант онд “Удирдлага болон нөөцийн үр ашгийг дээшлүүлж төрийн үйлчилгээний шуурхай байдал чанар хүртээмжийг сайжруулах” зорилго дэвшүүлсэн байна. Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг тавьж ажиллажээ. Үүнд:

Төрийн албаны болон холбогдох хууль тогтоомжуудыг ажилдаа мөрдлөг болгож, авлига, ашиг сонирхлын зөрчилд автахгүй байх.

Үйл ажиллагаандаа төрийн албаны стандартыг дагаж мөрдөн, дотоод ажлыг сайжруулах.

Ажлын цагийн ашиглалтыг сайжруулж, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний ажлын хөнгөн шуурхай байдлыг хангах.

Байгууллагын санхүүгийн болон бусад үйл ажиллагаанд ил тод байдлыг хангаж ажиллах.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Толбо сумын Засаг даргын тамгын газар нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль бусад холбогдох хууль, бусад хууль тогтоомжуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.

Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор тайлант оны 4 дүгээр сараас цалин нэмэгдсэнтэй холбоотой төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд өөрчлөлт орсон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2021, 2022, 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт, аудитын алба 2024 онд төлөвлөгөөт шалгалт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузаль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Толбо сумын Засаг даргын тамгын газрын даргын 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/19 тоот тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөж ажилласан байна.

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны 299 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 116.0 сая төгрөгөөр буурсан нь хуримлагдсан элэгдэлтэй холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	8,473.0	8,193.0	(280.0)
Урьдчилгаа			
Бараа материал	59,070.6	41,428.6	(17,642.0)
Үндсэн хөрөнгө	4,403,130.8	4,287,089.6	(116,041.2)
Нийт хөрөнгө	4,466,864.7	4,336,711.2	(130,153.4)
Өр төлбөр	3,809.72	0	(3,809.72)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,466,864.7	4,336,711.2	(130,153.4)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,466,864.7	4,336,711.2	(130,153.4)

Мөнгөн хөрөнгө данс оны эцэст үлдэгдэлгүй байна.

Авлага данс оны эхэнд хувь хүмүүсээс авах өвс, тэжээлийн үнийн 8.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсныг барагдуулж дахин зээлээр өвс, тэжээл тарааж, оны эцэст хувь хүмүүсээс авах 8.2 сая төгрөгийн авлагатай байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 41.4 сая төгрөг болж оны эхнээс 17.6 сая төгрөгөөр буурсан байна. Бичиг хэргийн материалын үлдэгдэл 0.8 сая, аж ахуйн материал 17.0 сая, бусад хангамжийн материал 23.6 сая төгрөг байна. Төсвийн хөрөнгөөр 63.2 сая төгрөгийн материал худалдан авч, Орон нутгийн хөгжлийн сангаас үнэ төлбөргүй 8.0 сая төгрөгийн бараа материал авсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 116.0 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд 280.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна. Тайлант онд дараах үндсэн хөрөнгийг олж бүртгэсэн байна. Үүнд: Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас 19.5 сая төгрөгийн хадлангийн хашаа 4-р баг, 29.9 сая төгрөгийн худаг, сумын Орон нутгийн хөгжлийн сангаас 65.7 сая төгрөг, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 43.8 сая төгрөг, Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 5.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Засгийн газрын оролцоо данс тайлант үеийн үр дүн 130.1 сая төгрөг байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 706.3 сая төгрөгөөр, зарлагыг 706.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагын 2024 оны анх батлагдсан төсөв 934.7 сая төгрөг байна. Үүнд: Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 934.7 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголоор 50.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгож баталсан байна

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрийн хувьд 985.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 912.9 сая төгрөгийн санхүүжилт авч, 895.6 сая төгрөгийг зарцуулж, санхүүжилтээс 17.3 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 895.6 сая төгрөг буюу 90.9 хувьтай байна. Энэ нь орон нутгийн төсвөөс 72.5 сая төгрөгийг дутуу авч, санхүүжилтээс 17.3 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

		/мянган төгрөгөөр/			
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага				
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	711,477.2	644,769.4	-66,707.8	90.6%
2	Туслах үйл ажиллагааны зардал	218,579.6	203,157.2	15,422.4	92.9%
3	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	38,953.0	37,902.0	1,051.0	97.3%
4	Орон нутгийн нөөц хөрөнгө	5,000.00	5,000.00	0.00	100%
5	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	11,430.9	4,808.0	6,622.9	42%
	Дүн	985,440.7	895,636.6	89,804.1	90.9%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Сумын Засаг даргын тамгын газрын үндсэн үйл ажиллагааны байр ашиглалтай холбоотой тогтмол зардалд хуваарилагдсан 33.5 сая төгрөгийг тайлант онд зарцуулаагүй байна. Сумын Санхүүгийн албанаас Аймгийн Эрчим хүчний зохицуулах хорооноос шинэчлэн баталсан халаалтын үнэ тариф нь батлагдаж ирээгүйгээс халаалтын зардалд нэг сард төлөх төлбөрийн хэмжээ тодорхойгүй гэх шалтгаанаар санхүүжилтийг олгоогүй, жилийн эцэст 33.5 сая төгрөгийн санхүүжилтийг сумын ерөнхий дансанд авч үлдсэн байна. Сумын төсөвт байгууллагуудыг халаалтаар хангадаг “Агайн” ХХК нь халаалтын төлбөрийг нэхэмжилж тооцоо хийгээгүйгээс санхүүгийн тайланд өглөгөөр тайлагнаагүй байна.

Санхүү-нийцлийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлийн судалгааны дүн дараах байдалтай байна. Үүнд:

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Толбо сумын Засаг даргын тамгын газар нь ахмадын сангийн харилцах данс нээлгээгүй, Ахмад настны тухай хуулийн 14.7 дахь заалтыг дагаж мөрдөөгүй байна.

Толбо сумын Засаг даргын тамгын газар нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гаргаж ажиллаагүй байна.

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн 210901 дансаар 30.6 сая төгрөгийг, бараа үйлчилгээний бусад зардлын 210801 дансаар 5.2 сая төгрөгийг зарцуулсан ба алдаа, зөрчил ирээгүй.

Байгууллагын 2024 оны орон тооны судалгааг гаргуулж авч, хянаж үзэхэд батлагдсан орон тооны хязгаарыг баримталж ажилласан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө ахмадын баярт зориулан 4.0 сая төгрөг, Статистикийн газраас мал тооллогын зардалд 3.3 сая төгрөг, сумын Орон нутгийн хөгжлийн сангаас өвс, тэжээлийн 20.6 сая төгрөг, нөхөн сэргэлтийн 3.0 сая төгрөг төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 5.2 сая төгрөг нийт 36.1 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авсан. Үүнээс: Мал тооллогын зардалд 3.3 сая төгрөг, ахмадын баярт 4.0 сая төгрөг, хог ачиж цэвэрлэсний зардалд 1.9 сая төгрөг, фонтод өвс бэлтгэхээр 13.1 сая төгрөг тус тус зарцуулж, төсөвт 13.8 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Толбо сумын Засаг даргын тамгын газар нь 2024 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Толбо сумын Засаг даргын тамгын газар нь 2024 онд батлагдсан төсвийн хүрээнд 63.2 сая төгрөгийн бараа материал худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Толбо сумын Засаг даргын тамгын газар нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Нурлан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар хэрэгжүүлсэн.

Толбо сумын Засаг даргын тамгын газар нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 23-ний өдрийн 3/16 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 733.5 сая төгрөгөөс 2 хувиар буюу 14.7 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны төсөв нэмэгдсэнтэй холбогдуулан 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,261.2 сая төгрөгөөс 2 хувиар буюу 25.2 сая төгрөгөөр аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоов.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой төсвийг хэмнэх талаар 29 арга хэмжээний хэрэгжилтийг шалгаж үзэхэд алдаа зөрчил илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансанд байршуулах мэдээллийг бүрэн оруулсан байна. Алдаа, зөрчил илрээгүй.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн төсвийн зарцуулалт нь Төсвийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,088.2 сая төгрөгийн алдаа¹ илэрч аудитын явцад залрууллаа. Үүнд:

Төсвийн гүйцэтгэлийн тайланд санхүүжих эх үүсвэрийг 895.6 сая төгрөгөөр алдаатай тайлагнасан, урсгал зардлыг 19.9 сая төгрөгөөр дутуу тайлагнасан, Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээж авсан 172.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, бараа материалыг хөрөнгийн санхүүжилтээр тайлагнасан нийтдээ 1,097.6 сая төгрөгийн алдааг залруулав.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 76 дугаар тушаалаар баталсан “Төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах журам”, 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам, УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 34.2 сая төгрөгийн зөрчил илэрч зөрчил арилгах 2 мөнгөн дүнтэй 1 мөнгөн дүнгүй нийт 3 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой асуудал

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

1.1.Илрүүлэлт: Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбогдуулан гарсан шатахууны зардлыг сумын ЗДТГ-ын дарга, нэгдүгээр гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтнаар дамжуулаагүй зарцуулсан нь төсвийн хөрөнгийг зарцуулалтад тавих хяналт сулрах магадлалтай байна.

1.2.Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

2.1.Илрүүлэлт: Бараа үйлчилгээний бусад зардлаас нийтдээ 16,264.4 мянган төгрөгийн гүйлгээг тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан байна.

2.2. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, 14.3.2, 14.3.3, 14.4, 14.4.1 14.4, 14.4.5 дахь заалтуудыг мөрдөж худалдан авсан бараа материалыг орлого авч тооцоо хийх, шууд зардлаар бүртгэж тайлагнасан зөрчлийг давтан гаргахгүй байх.

2. Шилэн дансны хэрэгжилттэй холбоотой асуудал

2.1.Илрүүлэлт: Шилэн дансанд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 4 шийдвэрийн 18,004.6 мянган төгрөгийн шийдвэрийг мэдээлээгүй, шилэн дансны хэрэгжилт 88.8 хувьтай байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Шилэн дансанд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 4 шийдвэрийн 18,004.6 мянган төгрөгийн мэдээллийг нөхөж байршуулан зөрчлийг арилгах, Шилэн дансны хуулийг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн гүйцэтгэлийн санхүүжих эх үүсвэрийг	1	895.636.6			1	895.636.6	1	895.636.6				

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

алдаатай тайлагнасан													
Үнэ төлбөргүй хүлээж авсан 172.7 сая төгрөгийн ҮХ, БМ-ыг хөрөнгийн санхүүжилтээр бүртгэж тайлагнасан	1	172,670.4			1	172,670.4	1	172,670.4					
Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн урсгал зардлыг 19.9 сая төгрөгөөр дууу харуулсан	1	19,925.9			1	19,925.9	1	19,925.9					
Дүн	2	1,088,232.9			2	1,088,232.9	2	1,088,232.9					

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан	1	16,264.4					1	16,264.4				
БНАТ тухай хуулийн дагуу зарцуулах хөрөнгийг 1-р гарын үсэг зарцуулаагүйгээс тавих хяналт суларсан байна.	1	0					1	0				
Дүн	1	16,264.4					1	16,264.4				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн	1	18,004.6						1	18,004.6

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

мэдээллийг байршуулаагүй								
Дүн	1	18,004.6					1	18,004.6
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								